



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

### Эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйл, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх баярын өдрүүдэд Нийслэлийн Эрүүл мэндийн газарт ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага болон хуваарьт цэгт хяналт тавих албан хаагчдын нэрс, хуваарийг хоёрдугаар, тус газрын болон харьяа эрүүл мэндийн байгууллагын мэдээний хүснэгтийг гуравдугаар, мэдээ авах албан хаагчдын нэрс, хуваарийг дөрөвдүгээр, харьяа эрүүл мэндийн байгууллагад хяналт тавих албан хаагчдын нэрс, хуваарийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Харьяа Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт ДААЛГАХ нь:

2.1.Баяр наадмын амралтын (2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 07 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд) өдрүүдэд байгууллага бүр хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг нийслэлийн Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт 77990101-01-04 дугаарын утсанд өглөөний 10:00 цагт, орой 19:00 цагт тус тус шуурхай мэдээлэх,

2.2.Баяр наадмын амралтын өдрүүдэд байгууллагын удирдлагууд харилцаа холбооны бэлэн байдлыг хангаж утсаа унтраахгүй байх, эргэж холбогдох, хотоос удаан хугацаагаар гарахаас зайлсхийх, зайлшгүй тохиолдолд газрын удирдлагад мэдэгдэн орлон ажиллах албан тушаалтныг томилох,

2.3.2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 16-ны өдөр хүртэл нийслэлийн Шүд, эрүү нүүрний төв хоёр кабинет (мэс засал, эмчилгээ), дүүргийн Эрүүл мэндийн төвүүдийн гэмтэл, мэс засал, дотор, шүдний кабинет, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд зохицуулалт хийж 10:00-15:00 цагийн хооронд тус тус ажиллуулах,

2.4.Хэвтүүлэн эмчлэх ор бүхий амаржих газар, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тосгоны эрүүл мэндийн төв нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд хүлээн авах, яаралтай болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ шаардагдах иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх,

2.5.Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун тослох материалын нөөцийг бүрдүүлэх, нэмэлтээр ажиллах хүний нөөц, автомашины бэлэн байдлыг хангах,

2.6.Баяр наадмын үеэр олон хоног амрахтай холбогдуулан байгууллагын болон тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын сахилга хариуцлагыг өндөржүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг

1550010235

авч, ажилчдын ажил, амралтын хуваарьт шаардлагатай зохицуулалтыг хийж, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах,

2.7.Тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, хүчилтөрөгч, хамгаалах хувцас хэрэгсэл, өвчтөний хоол, хүнсийг хүрэлцэх хэмжээгээр нөөцөлж, гал, ус цахилгааны аюулгүй байдлыг хангаж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ажилчдын сонор сэрэмжийг дээшлүүлэх,

2.8.Болзошгүй гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, хордлого, томоохон осол гэмтэл, халдварт өвчний үеийн авах арга хэмжээний бэлэн байдлыг ханган мэдээллийг зохих журмын дагуу шуурхай солилцон ажиллах, шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй авах,

2.9.Үер усны аюул, гэмтэж бэртэх, хоолны хордлого, нарших, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, баяр наадмын өдрүүдэд ажиллах байгууллагын цагийн хуваарь, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлах,

2.10.Тушаалыг хэрэгжүүлж баяр наадмын амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу амралтыг биеэр эдлүүлэх эсхүл батлагдсан төсөвтөө багтаан илүү цагийг тооцон олгох.

3.Болзошгүй гамшиг, үер усны аюул, гэмтэж бэртэх, хоолны хордлого, нарших, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, баяр наадмын өдрүүдэд ажиллах эрүүл мэндийн байгууллагын цагийн хуваарь, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ, байгууллагын цахим хуудсаар дамжуулан сурталчилж ажиллахыг Эрүүл мэндийг дэмжих, халдварт бус өвчний хэлтэс (Д.Цэнд-Аюуш), Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс (З.Болормаа), хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй хоолны хордлого, хордлогот халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хяналтын хэлтэс (М.Мөнхгэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

4.Баяр, амралтын өдрүүдийн өдөр тутмын нэгдсэн мэдээ тайланг нэгтгэж удирдлагад танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-т үүрэг болгосугай.

5.Баяр, амралтын өдрүүдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тайланг нэтгэн танилцуулахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож), хариуцлагатай жижүүр, хяналт болон мэдээ тайлан гаргаж ажилласан тус газрын албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу илүү цагийн хөлсийг тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Р.Дулмаа)-т тус тус даалгасугай.


6.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-т даалгасугай.

ДАРГА



П.ЭРХЭМБУЛГАН

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 09 -ны өдрийн  
1100 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Хариуцлагатай жижүүрээр ажиллах хугацаа	Жижүүрийн нэр	Утасны дугаар	Хяналт тавих албан тушаалтан
1.	2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл	Ц.Тамир	88082816	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
2.	2024 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл	Б.Тэргэлсаран	99171796	
3.	2024 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл	Б.Ариунзаяа	99009124	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
4.	2024 оны 07 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл	Д.Энхтуул	99044991	
5.	2024 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл	Г.Энхзул	99032400	Эрүүл мэндийг дэмжих халдварт бус өвчний хэлтсийн дарга
6.	2024 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл	Д.Жавхлан	89004852	

- Хариуцлагатай жижүүр нь тухайн өдрийн 09:00 цагаас дараа өдрийн 09:00 цаг хүртэлх 24 цагийн хугацаанд эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн асуудлыг бүрэн хариуцаж, зохицуулна.
- Заасан хугацаанд НЭМГ-т байрлан ажиллаж, харьяа байгууллагаас мэдээ авах хүснэгтийн дагуу мэдээг авч нэгтгэн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангаж, шаардлагатай байгууллага (ЭМЯ, НЗДТГ), албан тушаалтанд хүргүүлнэ.
- Хариуцлагатай жижүүр бүр тухайн өдрийн мэдээг нэгтгэн дараагийн хуваарьт жижүүрт хүлээлгэн өгнө.
- 2024 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагаас 21.00 цаг хүртэл гарсан хариуцлагатай жижүүр нь мэдээг эцсийн байдлаар нэгтгэн оройн 21.00 цагт НЭМГ-ын удирдлагад, 07 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цагт Эмнэлгийн тусламжийн хэлтэст тус тус хүлээлгэн өгнө.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн  
4/100 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт




**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА БОЛОН ХУВААРЬТ  
ЦЭГТ ХЯНАЛТ ТАВИХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ**

№	Албан хаагчын нэр	Хэлтэс	Албан тушаал	Төв цэнгэлдэх хүрээлэн	Хүй долоон худаг	Сүхбатаарын талбай	Утасны дугаар
1	Б.Батцоож	ЭТХ	Хэлтсийн дарга	07.12	07.10-11		99851206
2	Э.Есү	ЭТХ	Ахлах мэргэжилтэн	07.12	07.10-11		99207999
3	Ц.Сонгиносүрэн	ХШУДАХ	Ахлах мэргэжилтэн		07.10-12		99990642
4	Н.Мэндсайхан	ЭМДХБ ӨХ	Ахлах мэргэжилтэн		07.10-12		99131552
5	Д.Оюун-Эрдэнэ	ЭТХ	Ахлах мэргэжилтэн	07.10, 12		07.11	99168628
6	Н.Болдбаатар	ЭТХ	Ахлах мэргэжилтэн		07.10-13		91960099, 86055252
7	Н.Мөнхжаргал	ЭТХ	Мэргэжилтэн		07.10-12		99008942
8	Э.Энхзаяа	ЭТХ	Мэргэжилтэн	07.10-12			88067352
9	Д.Энхтүвшин	ХШУДАХ	Ахлах мэргэжилтэн		07.10-12		99198454
10	Б.Тэргэлсаран	ЭТХ	Мэргэжилтэн	07.10-12			99171796

Хяналт тавих албан хаагч нь тухайн өдөр 24 цагийн хугацаанд хуваарьт цэгт ажилласан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн асуудлыг бүрэн хариуцаж, зохицуулна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн  
А/100 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БОЛОН ХАРЬЯА ЭРҮҮЛ  
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ**

**Хүснэгт 1**

**“Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн  
эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэл АМ36” маягт**

№	Үзүүлэлт	Мөр	
1	Төрсөн эхийн тоо	1	“АМ36” маягтаар burtgel.mohs.mn программд өдөр бүр өглөөний 08.30 цагт мэдээлсэн байх.
2	Амьд төрсөн нярай	2	
3	Амьгүй төрсөн хүүхэд	3	
4	Нас барсан хүний тоо	4	
...		...	
40		105	

Бүх эрүүл мэндийн байгууллагууд баяр наадам, амралтын өдрийн мэдээг “АМ36” маягтаар burtgel.mohs.mn программд өдөр бүр өглөөний 08.30 цагт оруулсан байна.


**Хүснэгт 2**

**Хариуцлагатай жижүүрийн баяр, наадмын эмнэлгийн тусламж, үйлчилгээний мэдээ**

№	Мэдээ, хаанаас авах	Тусламж, үйлчилгээний төрөл	Сар, өдөр	Г. мэт	Нэгтгэл
1	Дүүргийн эрүүл мэндийн төвийн кабинетийн үзлэг  (16:00 цагт мэдээлэх)	Нийт үзлэг			
		Үүнээс	Дотор		
			Мэс засал		
			Гэмтэл		
		Шүд			
2	Өрхийн эрүүл мэндийн төвийн үзлэгийн мэдээ  (16:00 цагт мэдээлэх)	Нийт үзлэг			
		Үүнээс	Насанд хүрэгчид		
		Хүүхэд			

3	Төв цэнгэлдэх хүрээлэн  (09:00, 20:00 цагт мэдээлэх)	Нийт үзлэг				
		Үүнээс	Яаралтай тусламж үзүүлсэн хүний тоо			
			Наршсан			
			Гэмтсэн			
			Ходоод гэдэсний хурц хямрал			
			Бусад			
Эмнэлэгт хүргэгдсэн						
4	Хүй долоон худаг  (09:00, 20:00 цагт мэдээлэх)	Нийт үзлэг				
		Үүнээс	Яаралтай тусламж үзүүлсэн хүний тоо			
			Наршсан			
			Гэмтсэн			
			Ходоод гэдэсний хурц хямрал			
		Морьноос унасан хүүхдийн тоо				
		Үүнээс	Тархи нугасны гэмтэл			
			Зөөлөн эдийн гэмтэл			
			Хугарал			
			Эмнэлэгт хүргэгдсэн			
			Нас барсан			
<p>Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт 77990101-01-04 дугаарын утсанд хуваарьт цаг (10.00, 19.00)-ийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний талаарх ерөнхий мэдээллийг шуурхай мэдээлнэ.</p> <p>ДЭМТ, ӨЭМТ-ийн амбулаторийн үзлэгийн 19:00 цагийн мэдээ нь тухайн өдрийн нийт үзлэгийн мэдээ байх ба ӨЭМТ-ийн мэдээг ДЭМТ нь нэгтгэж өгнө.</p> <p>Наадмын талбай, Хүй-7 худагийн 20:00 цагийн мэдээг тухайн цагийн бодит дүнгээр авна. Өглөөний 09:00 цагийн мэдээ нь өссөн дүн буюу өмнөх бүтэн өдрийн мэдээ байна.</p>						


Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн  
АХ010 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭ АВАХ  
АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ

№	Мэдээ авах хугацаа	Мэдээ, тайлангийн төрөл	Мэдээ авах мэргэжилтний нэр	Холбогдох утас	Мэдээ авах хэлбэр
1	2024 оны 07 дугаар сарын 10-16-ны өдөр	1. Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх "АМ36" маягтын мэдээ	Ш.Мөнхзул	96969969	"АМ36" маягтаар burtgel.mohs.mn программд өдөр бүр өглөөний 08:30 цагт мэдээлэх
2		Ц.Сонгиносүрэн	90903190		
5		2. Тушаалын хоёрдугаар хавсралтын хоёрдугаар хүснэгтэд заасан мэдээ	Хариуцлагатай жижүүр	77990101-01-04	Заасан цагийн хуваарийн дагуу утсаар шуурхай мэдээлэх

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн  
100 дугаар тушаалын тавдугаар хавсралт



ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ХЯНАЛТ  
ТАВИХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Хяналт тавих байгууллага (дүүргээр)	Хяналт тавих ажилтан	Албан тушаал
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 15-ны өдрүүдэд			
1	Баянгол эрүүл мэндийн төв	Д.Оюун-Эрдэнэ	Ахлах мэргэжилтэн (99168628)
2	Баянзүрх Эрүүл мэндийн төв	Д.Энхтүвшин	Ахлах мэргэжилтэн (99198454)
3	Баянзүрх нэгдсэн эмнэлэг		
4	Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг	Б.Баатарсүх	Ахлах мэргэжилтэн (99063239)
5	Сонгинохайрхан эрүүл мэндийн төв		
6	Сүхбаатар нэгдсэн эмнэлэг	М.Мөнхгэрэл	Хэлтсийн дарга (99994051)
7	Сүхбаатар Эрүүл мэндийн төв		
8	Хан-Уул Эрүүл мэндийн төв	Б.Батцоож	Хэлтсийн дарга (99851206)
9	Хан-Уул нэгдсэн эмнэлэг		
10	Чингэлтэй Эрүүл мэндийн төв	Н.Болдбаатар	Ахлах мэргэжилтэн (91960099)
11	Наркологийн эмнэлэг		
12	Налайх эрүүл мэндийн төв	Д.Сайнхүү	Хэлтсийн дарга (99094294)
13	Багануур эрүүл мэндийн төв	Р.Дулмаа	Хэлтсийн дарга (99014624)
14	Багахангай эрүүл мэндийн төв		
15	Энэрэл эмнэлэг	Б.Баатарсүх	Ахлах мэргэжилтэн (99063239)
16	Нийслэлийн Түргэн тусламжийн төв	Н.Болдбаатар	Ахлах мэргэжилтэн (91960099)
17	Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв	Н.Мэндсайхан	Ахлах мэргэжилтэн (99131552)
18	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв	Б.Булганзаяа	Ахлах мэргэжилтэн (95954229)

19	Жаргалант тосгоны эрүүл мэндийн төв	О.Цэрэндэжид	Ахлах мэргэжилтэн (88037183)
20	Туул тосгоны эрүүл мэндийн төв		
21	Гачуурт тосгоны эрүүл мэндийн төв	Ц.Сонгиносүрэн	Ахлах мэргэжилтэн (99990642)
22	Хонхор тосгоны эрүүл мэндийн төв		
23	Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв	У.Бат-Очир	Хэлтсийн дарга (95999500)
24	Бяцхан тэмүүлэл хүүхдийн сэргээн засах төв		
25	Хантуул хүүхдийн сэргээн засах төв		
26	Амгалан амаржих газар	Ж.Паламжав	Ахлах мэргэжилтэн (99885996)
27	Хүрээ амаржих газар		
28	Өргөө амаржих газар		

Хяналт тавих албан хаагч нь тухайн өдөр 24 цагийн хугацаанд хариуцсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн асуудлыг бүрэн хариуцаж, зохицуулна.